



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/49/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Шинжээч Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
5.3 Зөвлөмж.....	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.23 № 01/02
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
П.ОЮУНБИЛЭГ ТАНАА

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитад шаардлагатай бичиг баримтыг бүрэн ирүүлээгүйгээс аудитын түүвэрт хамрагдсан 23 нэр төрлийн 39,928.4 мянган төгрөгийн бараа материалыг оршин буй эсэхийг тогтоох боломжгүй зөрчил илэрлээ. Энэ нь бараа материал дансны хувьд тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх", "Оршин байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна.

Тус байгууллага нь 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 28 зорилт 59 арга хэмжээтэйгээр төлөвлөн, 92,3 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн

төсөл арга хэмжээг бүрэн дуусгаж, хүлээн аваагүйгээс 164,376.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн газрын судалгаагаар 11 нэгж талбар бүртгэлтэй байгааг санхүүгийн тайланд бүртгэж тайлагнаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	56,709,316.40	224,543,222.86
33	АВЛАГА	7,261,700.00	170,325,546.46
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		317,849.46
335	Бусад авлага	7,261,700.00	170,007,697.00
3351	Байгууллагаас авах авлага	-	164,375,997.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	7,261,700.00	5,631,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	49,447,616.40	54,217,676.40
351	Түүхий эд материал	42,400,876.40	43,323,866.40
35110	Тусгай зориулалттай материал	42,400,876.40	43,323,866.40
354	Хангамжийн материал	2,046,740.00	5,893,810.00
35410	Бичиг хэргийн материал	911,520.00	1,655,620.00
35420	Аж ахуйн материал	550,000.00	550,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	535,000.00	3,615,000.00
35440	Түлш, шатах тослох материал	50,220.00	73,190.00
35600	Мал амьтад	5,000,000.00	5,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,128,357,510.35	1,274,355,580.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,128,357,510.35	1,274,355,580.66
392	Биет хөрөнгө	1,113,929,510.35	1,259,927,580.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	698,941,338.66	1,024,153,004.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(241,920,585.10)	(366,892,951.14)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	175,838,611.00	175,838,611.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(108,800,819.51)	(124,265,062.05)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	388,120,193.00	400,085,293.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(124,962,019.45)	(150,402,274.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	73,312,250.00	81,557,250.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,736,355.11)	(36,892,391.43)
39209	Зам, гүүрийн байгууламж	768,255,100.00	768,255,100.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(758,255,100.00)	(758,255,100.00)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,000,000.00	10,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	285,278,404.00	285,278,404.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(82,150,507.14)	(106,541,302.92)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	58,009,000.00	58,009,000.00
393	Биет бус хөрөнгө	14,428,000.00	14,428,000.00
39301	Програм хангамж	1,645,000.00	1,645,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(165,000.00)	(165,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,948,000.00	12,948,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,185,066,826.75	1,498,898,803.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	129,900.59	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	129,900.59	-
413	Өглөг	129,900.59	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	129,900.59	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,184,936,926.16	1,498,898,803.52
51	Засгийн газрын хувь оролцоо	1,184,936,926.16	1,498,898,803.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	575,954,182.52	575,954,182.52
51101	Өмч: - төрийн	575,954,182.52	575,954,182.52
512	Хуримтлагдсан үр дүн	403,504,670.28	717,466,547.64
51210	Өмнөх үеийн үр дүн	403,504,670.28	403,504,670.28
51220	Тайлант үеийн үр дүн	-	313,961,877.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	205,478,073.36	205,478,073.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,185,066,826.75	1,498,898,803.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	873,723,670.00	993,464,261.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	307,519,916.00	226,688,189.51
120	Нийтлэг татварын бус орлого	307,519,916.00	226,688,189.51
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	307,519,916.00	226,688,189.51
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	307,519,916.00	226,688,189.51
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	566,203,754.00	766,776,072.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	118,567,554.00	85,945,272.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,567,554.00	85,945,272.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	447,636,200.00	680,830,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	447,636,200.00	680,830,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	517,355,896.91	667,764,383.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	517,355,896.91	667,764,383.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	463,876,268.91	658,115,297.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,940,247.56	354,852,336.89
210101	Үндсэн цалин	146,461,742.56	294,572,429.18
210102	Нэмэгдэл	36,828,675.00	60,279,907.71
210104	Урамшуулал	5,649,830.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,935,336.03	44,352,145.69
210201	Тэтгэврийн даатгал	21,258,298.03	29,249,323.72
210202	Тэтгэмжийн даатгал	1,286,641.12	6,567,022.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	917,729.10	2,294,375.08
210204	Ажилгүйдлийн даатгал	296,854.60	729,299.35
210205	Эрүүл мэндийн даатгал	3,175,813.18	5,512,125.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,425,602.00	41,629,011.06
210301	Гэрэл, цахилгаан	3,559,480.00	3,375,242.06
210302	Түлш, халаалт	27,866,122.00	38,253,769.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,797,941.00	19,903,825.00
210401	Бичиг хэрэг	2,516,280.00	1,255,900.00
210402	Тээвэр, шатахуун	25,860,011.00	17,200,925.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,447,000.00
210408	Бараа материал акталсны зардал	5,221,650.00	
2105	Нормативт зардал	-	350,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		350,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,539,793.00	-
210604	Урсгал засвар	1,539,793.00	-
2107	Томилолт, зочны зардал	5,932,400.00	4,805,700.00
210702	Дотоод албан томилолт	5,932,400.00	4,805,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,220,769.00	1,690,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	15,110,919.00	117,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	438,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	283,850.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	253,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	158,084,180.32	190,532,278.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,857,970.00	46,274,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	120,226,210.32	144,257,828.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,479,628.00	9,649,086.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,043,170.00	1,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,368,700.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	990,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,684,470.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,000,000.00

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,436,458.00	8,649,086.31
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,436,458.00	8,649,086.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	356,367,773.09	325,699,878.04
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	153,891,934.64	11,738,000.68
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	153,891,934.64	11,738,000.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(153,891,934.64)	(11,738,000.68)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	202,475,838.45	313,961,877.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	566,203,754.00	766,776,072.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	566,203,754.00	766,776,072.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	118,567,554.00	85,945,272.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,567,554.00	85,945,272.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	447,636,200.00	680,830,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	447,636,200.00	680,830,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	486,203,654.00	512,413,175.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	486,203,654.00	512,413,175.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	432,724,026.00	502,764,088.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	179,999,905.00	355,221,207.02
210101	Үндсэн цалин	137,521,400.00	294,891,111.73
210102	Нэмэгдэл	36,828,675.00	60,330,095.29
210104	Урамшуулал	5,649,830.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,401,400.00	42,801,025.61
210201	Тэтгэврийн даатгал	16,949,600.00	29,150,113.51
210202	Тэтгэмжийн даатгал	1,770,400.00	3,413,434.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,420,400.00	2,817,550.15
210204	Ажилгүйдлийн даатгал	430,000.00	679,900.56
210205	Эрүүл мэндийн даатгал	3,831,000.00	6,740,027.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,661,372.00	41,629,011.06
210301	Гэрэл, цахилгаан	2,795,250.00	3,118,668.28
210302	Түлш, халаалт	27,866,122.00	38,510,342.78
2104	Хангамж, бараа материалын зардал	21,428,300.00	17,554,500.00
210401	Бичиг хэрэг	1,276,000.00	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,252,300.00	11,257,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,597,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,700,000.00	2,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	12,300,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	12,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,512,400.00	4,805,700.00
210702	Дотоод албан томилолт	5,512,400.00	4,805,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	30,321,807.00	14,105,695.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,211,957.00	12,935,695.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	438,000.00	438,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	283,850.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	132,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	138,898,842.00	14,346,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	138,898,842.00	14,346,950.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,479,628.00	9,649,086.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,043,170.00	1,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,368,700.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,674,470.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,436,458.00	8,649,086.31
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,436,458.00	8,649,086.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	80,000,000.00	254,362,897.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	80,000,000.00	254,362,897.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	80,000,000.00	254,362,897.00
2200	Дотоод эх үүсвэрээр	80,000,000.00	254,362,897.00
221001	Их засвар	80,000,000.00	164,375,997.00
222001	Тоног төхөөрөмж		3,587,200.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		86,399,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(80,000,000.00)	(254,362,897.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,954,182.52	205,478,073.36	403,504,670.28	0.00	1,184,936,926.16
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,954,182.52	205,478,073.36	403,504,670.28	0.00	1,184,936,926.16
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00		0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	575,954,182.52	205,478,073.36	403,504,670.28	0.00	1,032,563,524.24
D08	Тайлант үеийн үр дүн			313,961,877.36		313,961,877.36
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,954,182.52	205,478,073.36	717,466,547.64	0.00	1,498,898,803.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	569,155,500.00	494,218,516.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	569,155,500.00	494,218,516.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	533,862,900.00	493,218,516.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	358,576,800.00	332,912,488.02
210101	Үндсэн цалин	311,768,700.00	294,891,111.73
210102	Нэмэгдэл	46,808,100.00	38,021,376.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,822,100.00	40,012,417.61
210201	Тэтгэврийн даатгал	30,479,000.00	27,253,866.51
210202	Тэтгэмжийн даатгал	3,585,800.00	3,190,345.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,868,600.00	2,552,236.15
210204	Ажилгүйдлийн даатгал	717,200.00	635,279.56
210205	Эрүүл мэндийн даатгал	7,171,500.00	6,380,690.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,837,800.00	41,629,011.06
210301	Гэрэл, цахилгаан	3,709,200.00	3,118,668.28
210302	Түлш, халаалт	44,028,600.00	38,510,342.78
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	18,127,500.00	17,324,500.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,027,500.00	11,027,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	1,597,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариу	2,700,000.00	2,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,300,000.00	12,300,000.00
210604	Урсгал засвар	12,300,000.00	12,300,000.00
2107	Томиллот, зочны зардал	4,805,700.00	4,805,700.00
210702	Дотоод албан томиллот	4,805,700.00	4,805,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху	30,670,000.00	27,515,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээн	29,500,000.00	26,345,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	438,000.00	438,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	132,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,723,000.00	16,719,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,723,000.00	16,719,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,292,600.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,292,600.00	1,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,292,600.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	234,000,000.00	177,963,197.00
2200	Дотоод эх үүсвэрээр	234,000,000.00	177,963,197.00
221001	Их засвар	215,000,000.00	164,375,997.00
222001	Тоног төхөөрөмж	19,000,000.00	13,587,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	798,155,500.00	672,181,713.69
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	798,155,500.00	672,181,713.69
132001	Орон нутгийн төсвөөс	798,155,500.00	672,181,713.69
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	118,567,554.00	85,945,272.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	118,567,554.00	85,945,272.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	110,198,854.00	85,945,272.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	22,308,719.00
210102	Нэмэгдэл		22,308,719.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	2,788,608.00
210201	Тэтгэврийн даатгал		1,896,247.00
210202	Тэтгэмжийн даатгал		223,089.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		265,314.00
210204	Ажилгүйдлийн даатгал		44,621.00
210205	Эрүүл мэндийн даатгал		359,337.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	230,000.00
210402	Тээвэр, шатахуун		230,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	90,695.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		90,695.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,198,854.00	60,527,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,198,854.00	60,527,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,368,700.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,368,700.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,368,700.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	118,567,554.00	85,945,272.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	118,567,554.00	85,945,272.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	118,567,554.00	85,945,272.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээг иргэдэд хуулийн хүрээнд шуурхай хариуцлагатай шударга хүргэх эрхэм зорилготой байна.

Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 28 зорилт, 59 арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилт 92,3 хувиар хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

ЗДТГ-ын дотоод хяналтын зөвлөл нь байгууллагын үйл ажиллагаанд тайлант хугацаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь ЗДТГ-ын даргын 2019 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн тушаалаар батлагдсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинээр гарсан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад бүрэн нийцэхгүй болсон.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 313,832.0 мянган төгрөгөөр буюу 26,5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	7,261.7	170,325.5	163,063.8
Бараа материал	49,447.6	54,217.7	4,770.1
Үндсэн хөрөнгө	1,128,357.5	1,274,355.6	145,998.1
Нийт хөрөнгө	1,185,066.8	1,498,898.8	313,832.0
Өр төлбөр	129.9	-	-129.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,184,936.9	1,498,898.8	313,961.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,185,066.8	1,498,898.8	313,832.0

Дээрх хүснэгтээс харахад авлага дансны үлдэгдэл 170,325.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 163,063.8 мянган төгрөг болж өссөн нь дараах зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Наадмын талбайн засвар үйлчилгээг Есөн хэлхээ ХХК-д 125,376.0 мянган төгрөгийг, Азийн баялаг ХХК-д төрийн албан хаагчийн байрны засварт 39,000.0 мянган төгрөгийг шилжүүлж, ажлыг дуусаагүй, хүлээн аваагүй байхад барилга байгууламж дансанд капиталжуулан бүртгэж, тайлагнасан алдааг аудитын явцад залруулж, авлагаар бүртгэсэн.
- 12 дугаар сард олгосон 500.0 мянган төгрөгийн урьдчилгааг суутгаагүй зардалд бичиж тайлагнасныг залруулж авлагаар бүртгүүлсэн.
- Өмнөх оны аудитаар бичигдсэн 2,461.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.
- Мөн дансны оны эхний авлага 2,470.5 мянган төгрөгийг барагдуулаагүй, тайлант онд олгосон 200.0 мянган төгрөгийн урьдчилгааг суутгаагүй зэргээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 54,217.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,770.1 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС болон үнэ төлбөргүй орлогоор 11,094.0 мянган төгрөгийг, төсвийн хөрөнгөөр 48,404.8 мянган төгрөгийн орлогыг бүртгэж, 54,728.8 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагааны зардалд зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,274,355.6 мянган төгрөг болж, 145,998.1 мянган төгрөгөөр өссөн нь сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 05 дугаар тогтоолоор ЕБС-ийн 218,456.0 мянган төгрөгийн 83,741.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй дотуур байрны барилгыг балансаас балансад шилжүүлснийг бүртгэсэн, аймгийн хөрөнгө оруулалтаар хүүхдийн тоглоомын талбай 60,000.0 мянган төгрөг, сумын шилжих үлдэгдлээс 26,399.7 мянган төгрөгийн компьютер, принтер, канон зэрэг тоног төхөөрөмж, тавилга бэлтгэсэн. Мөн үнэ төлбөргүй орлогоор ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн 2 худаг, мал угаалгын ванн, цахим худгийн төхөөрөмжийг нийт 61,755.7 мянган төгрөгөөр, УИХ-ын гишүүний санаачилгаар ирүүлсэн 9,124.0 мянган төгрөгийн 4 ш зөөврийн компьютер, 10,000.0 мянган төгрөгөөр нойл, угаалтуур зэргийг бүртгэсэн ба тайлант онд нийт 385,735.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж, сумын ИТХ-ын 2023 оны 05 тоот тогтоолоор 30,313.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан, ЕБС-д 10,000.0 мянган төгрөгийн 65 инч дэлгэцтэй самбарыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,498,898.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 313,961.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 417,783.6 мянган төгрөг, нийт зарлагыг 417,783.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 125,609.3 мянган төгрөгөөр өсгөж, урсгал зардлыг 543,392.9 мянган төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг 15,000.0 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс 154,000.0 мянган төгрөг буюу 712,392.9 мянган төгрөгөөр баталсан байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төв аймгийн Угтаалцайдам сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 01 тоот тогтоолоор ЗДТГ-ын тайлант оны батлагдсан төсвийг 85,762.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 798,155.5 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 798,155.5 мянган төгрөг, үүнээс 234,000.0 мянган төгрөгийг орон нутгийн шилжих үлдэгдлээс бүрдүүлэхээр байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын ЗДТГ-т 2023 онд гүйцэтгэлээр нийт 680,830.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 672,181.7 мянган төгрөг буюу 84,2 хувьтай хэрэгжсэн нь батлагдсан санхүүжилт эх үүсвэрийг 117,324.7 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлж, зарцуулаагүй үлдэгдэл 8,649.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн хэрэгжилтэд батлагдсан орон дутуу ажилласнаас шалтгаалан үндсэн үйл ажиллагааны зардал 40,644.3 мянган төгрөгөөр, наадмын талбайн засвар болон төрийн албан хаагчдын байр засварын ажил бүрэн хэрэгжээгүйгээс бусад зардал 56,036.8 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж олгогдоогүйгээс тэтгэмжийн зардал 29,292.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-80101 үндсэн үйл ажиллагааны зардал	463,455.7	422,811.4	40,644.3	91,2%
2	70106-80106 баг хорооны үйл ажиллагааны зардал	50,984.2	50,984.2	0	100%
3	70106-80802 ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	30,292.6	1,000.0	29,292.6	3,3%
4	70106-80918 бусад	234,000.0	177,963.2	56,036.8	76,1%
5	70106-81102 орон нутгийн нөөц хөрөнгө	8,000.0	7,999.9	0,01	100%
6	70106-82801 улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0	100%
7	71411-81701 байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	3,723.0	3,723.0	0	100%
8	71411-82212 хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	2,700.0	2,700.0	0	100%
	Дүн	798,155.5	672,181.7	125,973.8	84,2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвөөс хагас жилийн мал тооллогын зардал 527.2 мянган төгрөг, зөвлөлдөх санал асуулгын 2-р шатны шатахууны зардал 230.0 мянган төгрөг, судалгааны зардал 90.7 мянган төгрөг, орон нутгийн нэмэгдэлд 22,308.7 мянган төгрөг, спорт чийрэгжүүлэлтийн талбай байгуулах 60,000.0 мянган төгрөг, бүгд 85,945.2 мянган төгрөгийн орлого төвлөрснийг тайлагнасан.

Нэмэлт санхүүжилтийн данснаас орон нутгийн нэмэгдэл 22,308.7 мянган төгрөг, шатахууны зардалд 847.9 мянган төгрөг, хүүхдийн тоглоомын талбайд 60,000.0 мянган төгрөг нийт 85,945.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023	Төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ.	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 94,1 % , сумын 2023 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 91,7%, төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 83,0%, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр 95 %-тай хэрэгжсэн	791,732.5	665,758.7
2	71411 хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2023	Хог хаягдлын хураамжийн төлөвлөгөөг 100% ханган биелүүлж, хог хаягдлыг тогтмол цэвэрлэн хур хог хаягдал үүсгэлгүй ажиллана.	2023 онд иргэн, ААНБ-с нийт 22.5 мянган төгрөгийн хог хаягдлын хураамжийн орлого төвлөрүүлсэн.	6,423.0	6,423.0
			ДҮН		798,155.5	672,181.7

Хөтөлбөрийн хэрэгжилт дутуу байгаа нь орон нутгийн санхүүжилтээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажил бүрэн хэрэгжээгүйгээс хөрөнгийн зардлыг 56,036.8 мянган төгрөгөөр дутуу, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 29,292.6 мянган төгрөг зарцуулагдаагүй, орон тоо дутуу ажилласнаас цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 30,474.0 мянган төгрөг хэмнэгдсэн зэргээс шалтгаалсан байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Угтаалцайдам сумын ЗДТГ нь тайлант оны худалдан авах ажиллагааны тайланг шилэн дансанд байршуулаагүй. Нээлттэй тендер шалгаруулалтаар 139,303.3 мянган төгрөгөөр наадмын талбайн засвар, 64,894.9 мянган төгрөгөөр төрийн албан хаагчдын орон сууцны засвар төсөл арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагыг шалгаруулсан байна. Хангамжийн материал болон тогтмол зардлыг харилцагч байгууллагуудтай шууд гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна.

Цахим дэлгүүрээс бараа материалын сонголтгүйгээс худалдан авалт хийгдээгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт шинжээч Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын даргын гарын үсэг зурж, тамга тэмдгээр албажуулаагүй 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/02 дугаартай албан бичгээр 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр цахимаар ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 663,994.4 мянган төгрөгийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн 2023 оны нийт зарлага 663,994.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 9,960.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,470.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна. Тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс олгосон урсгал зардлын санхүүжилт хэмнэгдэж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 8,649.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 176 мэдээллээс 5 мэдээлэл хугацаа хоцроосон, нэг мэдээлэл байршуулаагүй төлөвтэй байгаа боловч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг болон

эхний 10 сар хүртэлх цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг хоосон мэдээлсэн. Тайлант оны 268,431.6 мянган төгрөгийн орлогын, 83,248.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг дутуу мэдээлсэн ба мэдээлсэн байдлын хэрэгжилт хангалтгүй 67,4 хувьтай байна. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн албан шаардлага бичив.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын эхний гуравдугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж, шилэн дансны дутуу мэдээлсэн мэдээллийг нөхөн байршуулах, шууд худалдан авалтыг хийхдээ харьцуулалтын аргаар бэлтгэн нийлүүлэгчийг шалгаруулахдаа үнийн болон чанар байдлын харьцуулалт хийж тэмдэглэлээр баталгаажуулж, хамтын шийдвэрийг гаргаж байх гэсэн 2 зөвлөмж өгөгдөж, 170.2 мянган төгрөгийн төлбөрийн акт бичигдсэн.

Завсрын аудитаар өгөгдсөн төлбөрийн актыг барагдуулсан ба зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, зөвлөмж хоёр өгөгдсөнийг фас системд хэрэгжилтийг 100 хувь хэрэгжсэнээр мэдээлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	4,270.0	1	4,270.0	100
Албан шаардлага	1	2,891.5	1	2,891.5	100
Зөвлөмж	2	141,843.3	2	141,843.3	100
Нийт дүн	4	149,004.8	4	149,004.8	100

Өмнөх аудитаар өгөгдсөн шийдвэрийн хэрэгжилтийг хянахад төлбөрийн актыг бүрэн барагдуулсан ба шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Шатахуун олголт, тайлан гаргалт,

тооцоо бодолтод тавих хяналтыг сайжруулж, сар бүр тооцоог нэгтгэн бодож хэвших зөвлөмжийг аудитад баримт ирүүлээгүй тул давтан шалгах боломжгүй байна.

Авлага дансанд Төв МХГ-тай холбоотой эзэн тодорхойгүй авлагыг эзнийг тодруулж барагдуулах гэсэн албан шаардлагыг 430.0 мянган төгрөгийг барагдуулж 2,461.2 мянган төгрөгийг барагдуулаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн шийдвэрийн хэрэгжилтэд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 457,288.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 457,288.1 мянган төгрөгийн алдааг залруулж, Газрын албанаас ирүүлсэн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн газрын судалгаагаар 11 нэгж талбар бүртгэлтэй байгаагаас санхүүгийн тайланд нэг газар бүртгэлтэй байгаа алдааг залруулаагүйд зөвлөмж өгөгдлөө. Үүнд:

1.Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт төсвийн тухай хуулийн цаглавар хугацаанд буюу 2023 оны 01 дүгээр сарын 25-ны дотор ирүүлээгүй ба санхүүгийн тайланд төсвийн шууд захирагч гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж албажуулаагүй ирүүлсэн. Аудитаар:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөө 8,524.6 мянган төгрөгөөр төсвийн гүйцэтгэл зарлага 7,347.7 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй,
- Өмч өөрчлөлтийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээг 152,373.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тайлагнасан,
- Үндсэн хөрөнгө дансанд ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэсэн Соёлын төвийн 20,000.0 мянган төгрөгийн их засвар, сумын ЭМТ-д 29,150.0 мянган төгрөгийн ЭХО аппарат бэлтгэснийг ЗДТГ-т орлогоор бүртгэж, шилжүүлсэн,
- Наадмын талбайн засвар үйлчилгээг Есөн хэлхээ ХХК-д 125,376.0 мянган төгрөгийг, Азийн баялаг ХХК-д төрийн албан хаагчийн байрны засварт 39,000.0 мянган төгрөгийг шилжүүлж, ажлыг дуусаагүй, хүлээн аваагүй байхад барилга байгууламж дансанд капиталжуулан бүртгэсэн,
- Санхүү үр дүнгийн тайлангийн Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 275,838.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгө, бараа материалын тодруулга тайланд 351,354.6 мянган төгрөг буюу 75,516.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, нийт 457,288.1 мянган төгрөгийн алдаа илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2. Газрын албанаас ирүүлсэн Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн газрын судалгаагаар 11 нэгж талбар бүртгэлтэй байгааг санхүүгийн тайланд бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5-д “Хариуцлагатай байх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдээгүй, газрын анхан шатны баримт материал бүрдээгүй тул газрыг 2024 оны санхүүгийн тайланд бүртгэж тайлагнах зөвлөмж өгөв.

Аудитаар зөрчил² илэрсэн 236,520.5 мянган төгрөгийн зөрчилд 14,552.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 18,704.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 203,264.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

5.2 Төлбөрийн акт

1.Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл, цалин хөлсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмэгдэл олгох тухай” Б/02 тоот захирамж, Угтаал сумын сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн “Төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл, цалин хөлсийг шинэчлэн тогтоож, орон нутгийн нэмэгдэл олгох тухай” Б/03 захирамжийн дагуу 5 улс төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл 8,920.7 мянган төгрөг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Өмнөх оны аудитаар бичигдсэн 2,461.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, мөн 12 дугаар сард олгосон 500.0 мянган төгрөгийн урьдчилгааг суутгаагүй зардалд бичсэн, дансны өмнөх оны авлагын үлдэгдэл 2,470.5 мянган төгрөгийг болон 8 дугаар сард олгосон 200.0 мянган төгрөгийн урьдчилгааг төлүүлээгүй зэрэг нийт 5,631.7 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Албан шаардлага

Тайлант онд зарцуулсан 18,704.1 мянган төгрөгийн шатахууны тайлан, жолоочийн тооцоо бодсон баримтыг ирүүлээгүй тул давтан шалгах боломжгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн албан шаардлага бичив.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аудитын түүвэрт хамрагдсан бараа материалын 80 хувийг буюу 30,888.0 мянган төгрөгийн хөрөнгө тусгай зориулалттай материалын дансанд буруу ангилан бүртгэсэн байна. Тайлант онд ОНХС-аас 8,000.0 мянган төгрөгийн бод ээмгийг 4000 ш-ийг 2023 оны 7 дугаар сард орлогоор бүртгэсэн боловч зарцуулаагүй үлдэгдлээр байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Сангийн сайдын 2010 оны “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” 388 дугаар тушаалын 4.16-д “Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө” гэж заасантай болон санхүүгийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг үнэн зөв ангилан данс бүртгэлд тусгах ба хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

2. Хөрөнгө оруулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн наадмын талбайн засвар үйлчилгээг Есөн хэлхээ ХХК-д 125,376.0 мянган төгрөгийг, Азийн баялаг ХХК-д төрийн албан хаагчийн байрны засварт 39,000.0 мянган төгрөгийг шилжүүлж, ажлыг дуусаагүй, хүлээн аваагүй байхад барилга байгууламж дансанд капиталжуулан бүртгэсэн зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө оруулалтын ажлыг гэрээний хугацаанд чанартай хийж гүйцэтгэхэд хяналт тавьж, ажлыг комисс томилон хүлээн авч, анхан шатны баримт материалыг үндэслэн данс бүртгэлд үнэн зөв ангилан бүртгэж хэвших

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу Төв аймаг дахь Төрийн аудитын газарт батлагдсан төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 25-ны дотор, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж			
							За лр уу лс ан	Залруула агүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Буруу зөрүүтэй тайлагнасан	6	457,288.1			5	457,288.1	5	457,288.1	1	0	1	0
Дүн	6	457,288.1			5	457,288.1	5	457,288.1	1	0	1	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Өмнөх оны авлагыг барагдуулах албан шаардлага хэрэгжүүлээгүй, шинээр үүссэн урьдчилгааг төлүүлээгүй	1	5,631.7	1	5,631.7									
Бараа материалыг аудитад тооллогын бүртгэл тооцоо бодсон акт баримт ирүүлээгүй	1	39,928.4					1	39,928.4					
Жолоочийн тооцоо шатахуун зарцуулалтад өгсөн зөвлөмж хэрэгжээгүй	1	18,704.1			1	18,704.1							
Газрыг бүртгээгүй	1	0					1	0					
Дүн	4	64,264.2	1	5,631.7	1	18,704.1	2	39,928.4					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлэх гэсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Улс төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг	1	8,920.7	1	8,920.7				
Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлыг дутуу гүйцэтгэсэн	1	164,376.0					1	164,376.0
Дүн	2	173,296.7	1	8,920.7			1	164,376.0
Нийт дүн	3	173,296.7	1	8,920.7			2	164,376.0